



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2004 оны 8 сарын 16 өдөр

Дугаар 378

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Засгийн газрын 2004 оны "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 182 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хот байгуулалт, стратегийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дүрмийг нэгдүгээр хавсралтаар, Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэнгийн дүрмийг хоёрдугаар хавсралтаар, Хөрөнгө оруулалтын газрын дүрмийг гуравдугаар хавсралтаар, Нийтийн тээвэр зохицуулалтын газрын дүрмийг дөрөвдүгээр хавсралтаар, Гамшгаас хамгаалах штабын дүрмийг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Батлагдсан дүрмийг мөрдөж ажиллахыг Хэлтэс, газруудын дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2003 оны "Дүрэм батлах тухай" 549 дүгээр захирамжийн хоёрдугаар хавсралт, 2001 оны "Дүрэм батлах тухай" 23 дугаар захирамж, 2003 оны "Дүрэм батлах тухай" 99 дүгээр захирамжийн хоёрдугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

Durem-4

0201232



Нийслэлийн Засаг даргын 2004 оны
3.78 дугаар захирамжийн... 1.....
дугаар хавсралт

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХОТ БАЙГУУЛАЛТ, СТРАТЕГИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1 Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хот байгуулалт, стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь Улаанбаатар хотын хилийн цэс болон түүний дагуул суурины нутаг дэвсгэрт төрөөс явуулж буй хот байгуулалтын бодлогын хүрээнд нийслэлийн тогтвортой хөгжлийн стратегийг тодорхойлох, нийслэл Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгтгэх, уялдуулан зохицуулах, нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтыг нэгтгэх, тодорхой асуудлаар хөтөлбөр, төслүүд боловсруулах, нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, тухайн жилийн зорилт, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн боловсруулалт, хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулах, нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын мэдээллийн сан, сүлжээ байгуулах, мэдээллийн технологийн шинэчлэлт хийх үүрэг бүхий Тамгын газрын хэлтэс мөн.

1.2 Хэлтэс нь нийслэлийн Засаг дарга, Засаг даргын орлогч, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын удирдлага болон Ерөнхий архитекторын мэргэжлийн удирдлагад ажиллаж, хариуцсан ажлын чиглэлээр Монгол улсын Засгийн газар, төрийн яамд болон мэргэжлийн бусад байгууллагын шийдвэрийг нийслэлд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ажлаа тайлагнана.

1.3 Хэлтэс нь нийслэлийн Засаг даргын Тамгын газрын болон, Захирагчийн ажлын албаны хэлтсүүд, Засаг даргын дэргэдэх газар, албад болон нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн үйл ажиллагааг хариуцсан ажлын чиглэлээр мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана.

1.4 Хэлтсийн даргыг ажилд томилох, чөлөөлөх асуудлыг нийслэлийн Засаг дарга шийдвэрлэх бөгөөд бусад ажилтныг ажилд томилох, чөлөөлөх асуудлыг хэлтсийн даргын саналыг харгалзан нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга шийдвэрлэнэ.

1.5 Хэлтсийн дарга нь нийслэлийн Хот байгуулалт, газар зохион байгуулалтын мэргэжлийн комиссын орлогч дарга байна.

1.6 Хэлтэс нь барилгын зураг төслийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж харилцан мэдээлээр хангаж ажиллана.

1.7 Түүхийн дурсгалт барилга байгууламжийг бүртгэх, хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, архитектурын дэвшилтэт төлөвлөлт, орон зай ашиглалтыг

сайжруулах, барилга угсралтын ажилд шинэ техник технологи нэвтрүүлэх талаар төрийн бус мэргэжлийн байгууллагууд, уран бүтээлчид, инженер техникийн ажилчид, барилгачидтай хамтран ажиллаж болно.

1.8 Хот байгуулалтын бодлого, төлөвлөлт, тэдгээрийг хэрэгжүүлэх зураг төслийг нутгийн захиргааны байгууллага болон олон нийтэд хүргэн ойлгуулах, сурталчлах замаар тэднийг хэрэгжилтийн үйл ажиллагаанд оролцуулах оролцоог хангаж ажиллана

Хоёр. Хэлтсийн удирдлага, ажлын зохион байгуулалт

2.1 Хэлтэс нь ажлаа жил, улирлаар төлөвлөж, тайлан гаргана.

2.2 Тус хэлтсийн даргын ээлжийн амралт, удаан хугацааны сургалт, томилолт, өвчтэй, чөлөөтэй үед хэлтсийн удирдлагыг хот байгуулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн албан ёсоор гүйцэтгэнэ.

2.3 Хэлтсийн дарга нь холбогдох хууль тогтоомж, энэ дүрэм, нийслэлийн удирдлагаас өгсөн удирдамжийн дагуу хэлтсийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан батлуулж, тэдний өдөр тутмын ажлыг удирдлагаар ханган, цаг үеийн ажлыг зохион байгуулж, дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

2.3.1. Ажилтан бүрийг улирлын төлөвлөгөөтэй ажиллуулж, улирлаар ажлын тайлан гаргуулж, мэргэшлийн ур чадварыг үнэлж дүгнэнэ.

2.3.2. Хэлтсийн жил, улирлын төлөвлөгөө, тайлангийн боловсруулалт, хэрэгжилтэнд хяналт тавьж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авна.

2.3.3 Хэлтсийн дотоод ажлыг зохион байгуулж, хууль тогтоомж, шийдвэр, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, захирамж, тухайн жилийн зорилт, удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхийн тулд хэлтсийн ажилтнуудад хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг гаргуулан дүгнэж ажиллана.

2.3.4 Хэлтсийн нэрийн өмнөөс нийслэлийн нутаг дэвсгэр дэх төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй харилцаж ажиллана.

2.3.5 Хэлтсийн ажилтныг ажилд авах, ажлаас чөлөөлөх, урамшуулах, сахилгын арга хэмжээ авах, гадаад, дотоодод сургалтад хамруулах зэрэг асуудлаар удирдлагад уламжилж шийдвэрлүүлнэ.

2.4 Хэлтсийн шуурхай зөвлөлгөөнийг 14 хоног тутамд хийж, нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын удирдах хариуцлагатны шуурхай зөвлөлгөөний явц, удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх болон хэлтсийн ажилтнуудаас хариуцан гүйцэтгэх цаг үеийн ажил, албан хаагчдын ёс зүй, хариуцлага санаачлага, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, ажлын арга барил, үр төлөөг сайжруулах зэрэг асуудлыг хэлэлцэж тэмдэглэл хөтөлнө.

Гурав. Хэлтсийн үүрэг

3.1 Хэлтэс нь Нийслэлийн хөгжлийн хэтийн төлөвийн талаар баримтлах бодлогыг тодорхойлох, Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар нийслэлд хэрэгжих

хөтөлбөр, төслийн баримт бичиг, зураг төслийг зөвшөөрөлцөж, хяналт тавьж ажиллана.

3.2 Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хот байгуулалтын зураг төсөл, хөтөлбөр төслүүд, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлсон захиалгад саналаа тусган, хянаж хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулан шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулна.

3.3 Нийслэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулахад шаардлагатай Зургийн даалгавар, Архитектур төлөвлөлтийн даалгаврыг боловсруулан батлуулна.

3.4 Батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинээр баригдах болон өргөтгөх, давхарлах барилга байгууламжийн байршилт тогтоохдоо Улаанбаатар хотын ерөнхий архитектортой зөвшилцсөний дагуу холбогдох мэргэжлийн байгууллагуудын саналыг харгалзан нийслэлийн Хот байгуулалт, газар зохион байгуулалтын мэргэжлийн комиссын хурлын дүгнэлтийг үндэслэн Нийслэлийн Засаг даргын захирамжаар шийдвэрлүүлнэ.

3.5 Газар олголтын захирамж гарсны дагуу газрын дуудлага худалдааны материал бүрдүүлэх, бэлтгэл хангуулах ажлыг зохион байгуулна.

3.6 Архитектур, хот төлөвлөлтийн онцлог байршил бүхий барилгын зураг төсөл сонгон шалгаруулах уралдаан зарлан дүгнэх ажлыг зохион байгуулна.

3.7 Шинээр барих, өргөтгөх, давхарлах, засварлах, зам гүүр, барилга, инженерийн байгууламжийн зураг төсөл боловсруулах даалгавар, архитектур төлөвлөлтийн даалгаварыг боловсруулж, батлуулна.

3.8 Нийслэлийн инженерийн хангамжийн найдвартай ажиллагааг хангах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс горимын тооцоог шинэчлэх ажлыг зохион байгуулж мөрдөж ажиллана.

3.9 Шинээр барих, өргөтгөх барилга байгууламжийн инженерийн хангамжийн техникийн нөхцөлд санал өгч хэрэгжилтэнд хяналт тавин нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

3.10 Архитектур төлөвлөлтийн даалгаварыг үндэслэн хийгдсэн зураг төслийг зөвшөөрөлцөнө.

3.11 Нийслэлд барилгын ажлыг стандартын шаардлага хангасан материалаар хангах бодлогыг тодорхойлон хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.

3.12 Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газар хөдлөлтийн бичил лужлал, инженер геологийн дүгнэлтийг шинэчлэн тодотгох ажлыг зохион байгуулан хэрэгжүүлэн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.13 Сахилга дэг журам, ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээг сахиулж, иргэд, байгууллагын санал хүсэлтийг хуулинд заасан хугацаанд хөнгөн шуурхай барагдуулан өргөдөл гомдлын талаарх мэдээг сар бүр гарган тайлагнана.

3.14 Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр болон нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн тухайн жилийн зорилтыг нэгтгэн боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг нэгтгэн гаргана.

3.15 Хэлтэс нь нийслэлийн эдийн засаг, нийгэм, хотын хөгжлийн асуудлуудтай холбогдсон хөтөлбөр, төслүүдийг боловсруулах, шийдвэрлүүлэхэд оролцож мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.

3.16 Нийслэлд зах зээлийн харилцааг боловсронгуй болгох, хувийн хэвшил, олон нийтийн оролцоог дэмжихэд баримтлах бодлого, зарчмыг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллана.

3.17 Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, тухайн жилийн зорилт, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулна.

3.18 Улаанбаатар хотын авто замын сүлжээг хөгжүүлэх авто зам, замын байгууламжийг барих, өргөтгөн шинэчлэх, засварлах, арчлан хамгаалах бодлого боловсруулж төлөвлөнө.

3.19 Улаанбаатар хотын зам, тээврийн сүлжээг хөгжүүлэх, тэдгээрийн материаллаг баазыг бэхжүүлэхэд дотоодын хөрөнгө болон гадаадын зээл, хандивлагчдын тусламжтайгаар хэрэгжүүлэх төслүүдийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, төслийн хэрэгжүүлэгчийг сонгох ажиллагаанд оролцоно.

3.20 Шинээр гаргах авто замын орц гарц, авто машины зогсоолын талбайтай холбоотойгоор иргэд аж ахуйн нэгж байгууллагуудын хүсэлтийг судлаж Хот байгуулалт, автозамын хууль тогтоомж, Барилгын норм дүрмийн дагуу төлөвлөж зөвшөөрлийг олгоно.

3.21 Хотын ерөнхий төлөвлөгөө, авто замын сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөөтэй уялдуулан шинээр баригдах авто замын техникийн даалгаврыг батлана.

3.22 Хот байгуулалт төлөвлөлт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор хотын доторхи замын хөдөлгөөний чиглэл тогтоох, замын аюулгүйн зурвас дээр гарц гаргах, авто замын үзэгдэх орчинг хангахын тулд авто замын улаан шугамын доторхи реклам сурталчилгааны объектуудын байршлыг тогтоох ажилд оролцоно.

3.23 Шинээр баригдах барилга байгууламжуудын ерөнхий төлөвлөгөөг баталгаажуулах ажилд оролцоно.

3.24 Газрын тухай холбогдох хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэх, шаардлагатай газарт кадастрын зураглал, хийлгэх ажлыг зохион байгуулах, баталгаажилттай холбогдон гарсан газрын зөрчлийг хянаж шийдвэрлүүлнэ.

3.25 Нийслэлийн Газрын албанаас боловсруулсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын газар ашиглах, эзэмших эрхийн газрын баталгаажуулалтанд хяналт тавина.

3.26 Хот байгуулалтын бодлого, хотын ерөнхий төлөвлөгөөтэй холбогдон гарсан зөрчил маргааны асуудлыг шийдвэрлэнэ.

3.27 Нийслэлийн орон сууцны хангамж, дэд бүтцийн хөгжлийн /цахилгаан, дулаан, холбоо, цэвэр, бохир ус, зам, замын барилга байгууламж, нийтийн тээвэр, үерийн далан суваг, хотын инженерийн бэлтгэл арга хэмжээ/ талаар баримтлах бодлогыг боловсруулах, салбарын байгууллагуудын үйл ажиллагааг бодлогын хувьд уялдуулан зохицуулна

3.28 Нийслэлд байгаль орчныг хамгаалах, нөөц баялгийг нь зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэгдсэн бодлогыг боловсруулах ажлыг зохион байгуулна

3.29 Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд мэдээлэл, холбооны технологийг нэвтрүүлэх, мэдээллийн сангууд болон мэдээллийн сүлжээ байгуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана

3.30 Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын компьютерүүдийн гадаад, дотоод сүлжээ болон техник хэрэгслийн найдвартай ажиллагааг хангаж ажиллана

Дөрөв. Хэлтсийн эрх

4.1 Нийслэл Улаанбаатар хот болон түүний алслагдсан суурины нутаг дэвсгэрт хот байгуулалт, барилгажилтын дэг журмыг сахиулж, гарсан зөрчлийн холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэнэ.

4.2 Нийслэл хотын нутаг дэвсгэр дээр баригдаж буй барилгын батлагдсан зураг төсөл, ерөнхий төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг шаардан гаргуулж шалгана.

4.3 Батлагдсан зураг төслийг зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцон барагдуулах арга хэмжээ авах бөгөөд шаардлагатай тохиолдолд хяналтын байгууллагад уламжлан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна.

4.4 Шинээр баригдаж буй барилга байгууламжийн төсөвт барилгажилт зам талбайн тохижилтыг нөхөн сэргээх ажлын зардлыг тусгуулж, хэвийн нөхцөлд оруулах арга хэмжээ авна.

4.5 Барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авах ажлын комиссын гишүүнээр оролцож ажиллана.

4.6 Хот байгуулалтын холбогдолтой дүрэм, журам, норм нормативт өөрчлөлт оруулах тухай санал боловсруулан холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлнэ.

4.7 Нийслэлийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, хот байгуулалтын хөтөлбөр, төсөл, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар санал боловсруулж шийдвэрлүүлэх, тэдгээрийн биелэлтийн хэрэгжилтэнд хяналт тавина

4.8 Нийслэлийн хөгжлийн хэтийн болон жилийн үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөр, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, хөгжлийн төсөл, хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой асуудал боловсруулах, нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, тухайн жилийн зорилт, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн боловсруулалт, хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгөхөд шаардагдах зураг, схем, судалгаа, тооцоо, мэдээ тайлан зэрэг материалыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын болон Захирагчийн ажлын албаны хэлтэс, дүүргийн Засаг даргын Тамгын газар, харъяа байгууллага, алба, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжүүдээс гаргуулан авах, судалгаа тооцоо хийх зэрэгт холбогдох мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулна.

4.9 Хэлтсийн эрхэлж буй асуудлаар семинар, зөвлөлгөөн, сургалт зохион байгуулна

4.10 Хэлтэс нь нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн албаны хэлтсүүд, Засаг даргын дэргэдэх газар, албад болон нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын ажил төрлийн холбоотой хэлтсүүдийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана

4.11 Хот байгуулалт, газрын харилцаа, байгаль экологи зэрэг ажлын шууд холбоотой мэдээллийн сангуудаас холбогдох мэдээллийг үнэ төлбөргүй авч ашиглах ба мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдоно

4.12 Хэлтэс нь батлагдсан ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж шаардлагатай тохиолдолд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад оролцоно.

4.13 Нийслэлийн төр захиргааны байгууллагуудтай ажлын уялдааг ханган хамтран ажиллана

Тав. Хариуцлага

5.1 Энэхүү дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох ба өөрчлөлт нь дүрмийн салшгүй хэсэг болно.

-----oOo-----

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ЗУРАГ ТӨСЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ДҮРЭМ

I Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ зураг төслийн хүрээлэн нь цаашид "Хүрээлэн" гэх нийслэл хотыг шинжлэх ухааны үндэстэй хөгжүүлэх зорилгоор бүс нутгийн хөгжлийн төсөл, нийслэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын зураг төсөл боловсруулах, үнэлгээ тогтоох үндэслэл гаргах, барилга байгууламжийн зураг төсөл зохиох, зөвшөөрөлцөх, хяналт тавих, батлах, хот байгуулалт, газрын мэдээллийн санг бүрдүүлэх, хот судлал, хот байгуулалтын эрдэм шинжилгээний ажлыг эрхлэх үүрэг бүхий орон нутгийн байгууллага мөн.

1.2. Хүрээлэнгийн үйл ажиллагаа нь эрдэм шинжилгээ, зураг төслийн ажлаар дамжуулан нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтыг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан, нийслэлийн хот байгуулалтын хөгжлийн үзэл баримтлал, бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

1.3. Хүрээлэн нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль Газрын тухай, Хот байгуулалтын тухай, Барилгын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжууд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын захирамж, шийдвэр, мөрийн хөтөлбөр, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.4. Хүрээлэн нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг, өөрийн үйл ажиллагаа, үүрэг зорилтыг илэрхийлсэн билэгдэл, банкинд харилцах данстай байна.

1.5. Хүрээлэн нь үйл ажиллагааныхаа үр дүнг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн өмнө тайлагнана.

1.6. Хүрээлэн нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах нийслэлийн өмчит үйлдвэрийн газар мөн.

Хоёр. Хүрээлэнгийн удирдлага, зохион байгуулалт

2.1 Хүрээлэнгийн захирлыг Нийслэлийн Засаг даргын захирамжаар томилж, чөлөөлнө. Хүрээлэнгийн захирал нь Улаанбаатар хотын ерөнхий архитектор байна.

2.2 Улаанбаатар хотын ерөнхий архитектор нь хүрээлэнгийн үйл ажиллагааны хүрээнд өөрийн дүрмийг батлуулан мөрдлөг болгон ажиллана.

2.3 Хүрээлэн нь хоёр дэд захиралтай байх бөгөөд хүрээлэнгийн захирал нь Нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн томилж, чөлөөлнө.

2.4 Хүрээлэнгийн захирлыг ээлжийн амралт, өвчтэй, чөлөөтэй, удаан хугацааны сургалт, томилолттой байх хугацаанд хүрээлэнгийн удирдлагыг дэд захирлууд албан ёсоор гүйцэтгэнэ.

2.5 Хүрээлэн нь:

- а) Хот төлөвлөлт, архитектур, бүс нутгийн хөгжил, эрдэм шинжилгээний;
- б) Хотын менежментийн гэсэн хэлтсүүдтэй байна.

2.6 Хүрээлэн нь мэдээлэл технологийн нэгдсэн сан буюу төвтэй байна.

2.7 Хүрээлэнгийн захирлын дэргэд байгууллагын ойрын болон хэтийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий зөвлөлтэй байна. Зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг хүрээлэнгийн захирал батлана.

2.8 Хот байгуулалт, дэд бүтэц, инженерийн хангамжийн талаар, зураг төслийн шилдэг шийдэл, судалгааны ажлын чиглэлээр оновчтой шийдэл гаргах зорилгоор эрдэм-техникийн мэргэжлийн зөвлөлтэй байна.

2.9 Хүрээлэнгийн шуурхай зөвлөлгөөнийг 14 хоног тутамд хийж, нийслэлийн төр захиргааны байгууллагуудаас удирдах хариуцлагатны шуурхай зөвлөлгөөний явц, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх болон хүрээлэнгийн ажилтнуудаас хариуцан гүйцэтгэх цаг үеийн ажил, албан хаагчдын ёс зүй, хариуцлага санаачлага, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, ажлын арга барил, үр нөлөөг сайжруулах зэрэг асуудлыг хэлэлцэж тэмдэглэл хөтөлнө.

2.10 Захирал нь эрх хэмжээний хүрээнд тушаал, заавар, журам гаргаж мөрдүүлэн ажиллана.

2.11 Захирал нь хүрээлэнг төлөөлж дараах эрх эдлэнэ.

- 2.11.1 Хүрээлэнгийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг хангуулах
- 2.11.2 Хүрээлэнгийн эрхлэх ажлын хүрээнд гадаад, дотоодын байгууллага, иргэдтэй шууд харьцаж, гэрээ хэлцэл хийх
- 2.11.3 Хүрээлэнгийн эд хөрөнгийг Монгол улсын хууль тогтоомж, дүрмийн дагуу ашиглах, зарцуулах
- 2.11.4 Хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалтыг жилийн ажлын хэмжээтэй уялдуудан өөрчлөх, боловсронгуй болгох, орон тоо, цалингийн санг тогтоох
- 2.11.5 Хүрээлэнгийн нийт ажилтан, ажилчдыг томилох, чөлөөлөх, цалингийн хэмжээг тогтоох
- 2.11.6 Хүрээлэнгийн гүйцэтгэж буй ажил, үйлдвэрлэл, технологийн болон судалгааны нууцад хамаарах мэдээллийг тогтоож хяналт тавих
- 2.11.7 Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан хүмүүсийг төр, засгийн болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шагналд уламжлах, газрын шагналаар шагнах

Гурав. Хүрээлэнгийн үүрэг

3.1. Нийслэлийн бүс нутгийн төлөвлөлт, хотын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалт, техник эдийн засгийн үндэслэл, барилга байгууламжийн зураг төслийг зохиох эдгээртэй холбогдолтой эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, санал дүгнэлт гаргах, хяналт тавих

3.2. Хот байгуулалтын бодлогыг зах зээлийн эдийн засгийн нийтлэг хандлагад нийцүүлэн хот байгуулалтын эдийн засгийн үнэлгээ боловсруулж, хэрэгжүүлэх

3.3. Хот байгуулалтын баримт бичгийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргаар уламжлуулан Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд оруулж батлуулна.

3.4. Хот байгуулалтын холбогдолтой дүрэм, журам, норм нормативт өөрчлөлт оруулах тухай санал боловсруулж, батлуулах

3.5. Зураг төслийг боловсруулахдаа холбогдох норм, норматив, стандартыг мөрдөж, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж, холбогдох байгууллагуудын саналыг тусгах

3.6. Тухайн жилд эзэмшил ашиглалтанд шинээр олгогдох газрын байршлыг сонгон, ерөнхий төлөвлөгөөний дагуу төлөвлөж, жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулна.

3.7. Нийслэлийн бүс нутгийн хөгжлийн төсөл, Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, тэдгээрийн хүрээнд хийгдсэн инженер геологийн судалгаа бусад зориулалтын зураглал, хилийн цэсийн баталгаат баримт бичгүүд, геодезийн цэг тэмдэгтүүд, зам тээвэр, инженерийн шугам сүлжээний хэтийн төлөвийн зураг төсөл болон бусад холбогдох баримт бичгийг зохих шаардлагын хэмжээнд бүрдүүлж, нууцын болон архивын материалуудын иж бүрэн судалгаа, бүртгэл хөтөлж ашиглах, тодотгол, шинэчлэлт хийх ажлыг зохион байгуулна.

3.8. Мэдээлэл технологийн төв нь газрын харилцаа, байгаль, экологи зэрэг ажлын шууд холбоотой мэдээллийн сангуудаас холбогдох мэдээллийг үнэ төлбөргүй авч мэдээллийн нэгдсэн санд нэгтгэнэ.

3.9. Хот байгуулалтын мэдээллийн санг эрхлэн мэдээ, мэдээллийн тодотгол шинэчлэлт хийх, дэд бүтэц, байгаль орчны мэдээллийн динамик сан байгуулах

3.10. Хот байгуулалтын мэдээллээр иргэдэд үйлчлэх

3.11. Хот байгуулалтын баримт бичгийн төслүүдийг олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулах

3.12. Иргэд аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хуулинд заасан хугацаанд хөнгөн шуурхай хүлээн авч, барагдуулна.

3.13. Зураг төсөл, судалгааны ажилд тэргүүний техник технологи нэвтрүүлэх, автоматжуулах, мэргэжилтнүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, давтан сургах, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах арга хэмжээ авах

3.14. Байгууллагын хэмжээнд сахилга дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийг хадгалалт, хамгаалтанд хяналт тавьж ажиллана.

3.15. Хүрээлэнгийн захирлын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраар хянуулна.

Дөрөв. Хүрээлэнгийн эрх

4.1 Нийслэлийн нутаг дэвсгэрт газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх үйл явц хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийцэж буй эсэхэд хяналт тавих

4.2 Хотын ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд санал өгч, тусгуулах

4.3 Хүрээлэнгээс боловсруулсан Улаанбаатар хот болон түүний хаяа хот, суурины, бүсийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, төсөл хөтөлбөрийн зохиогчийн эрхийн дагуу хяналт тавьж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд байнга оролцох

4.4 Батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинээр барих болон өргөтгөх, давхарлах барилга байгууламжийн байршил тогтооход санал өгөх, баталгаажуулах

4.5 Улсын хэмжээнд баригдаж байгаа барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах

4.6 Архитектур, хот байгуулалтын үнэт өвийг илрүүлэх, бүртгэл хяналтанд авах, хамгаалах, сэргээн завсарлах, үндэсний архитектурын уламжлалыг хөгжүүлэх талаар холбогдох байгууллагуудад санал оруулах, шийдвэр гаргуулах

4.7 Нийслэлийн бүс нутгийн хөгжлийн төсөл, Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, шинэчлэлийн зураг төсөл, судалгааны ажилд шаардагдах мэдээлэл, нэмэлт материалуудыг холбогдох байгууллага, албан тушаалтнаар гаргуулах

4.8 Зураг төслөөр дамжуулан барилгажилт, инженерийн хангамжийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх, өртөг зардлыг хэмнэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, дэвшилтэт үйл ажиллагаа явуулах шинжлэх ухааны үндэслэлийг тодорхойлох

4.9 Нийслэлийн бүс нутгийн онцлог, архитектур төлөвлөлт, барилгажилтын дүр төрхийг бий болгох, үндэсний архитектурын уламжлалыг сэргээх тохижилт, чимэглэл, гоо зүйн түвшинг дээшлүүлэх, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор сонгон шалгаруулах уралдаан зарлах, уран бүтээлийн уралдаан зарлан дүгнэх, сурталчлах, бүтээлийг хэрэгжүүлэх, уран бүтээлийн үзэсгэлэн гаргах, зөвлөлгөөн, онол-практикийн хурал зохион байгуулах

4.10 Улсын болон нийслэлийн даалгавартай ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх ба аж ахуйн нэгж, байгууллагын захиалга авч гэрээ байгуулан ажиллах

4.11 Хүрээлэнгийн үйл ажиллагааг өргөтгөх, зураг төслийн байгууллагуудын туршлага судлах, нэвтрүүлэх зорилгоор гадаад, дотоодын зураг төслийн байгууллагуудтай гэрээ байгуулж, мэргэжилтнүүдийг урьж ажиллуулах

4.12 Эрдэм шинжилгээ, төсөл хөтөлбөр боловсруулах түүнийг хэрэгжүүлэх ажил болон түүнд шаардагдах техник, тоног төхөөрөмж, норм нормативын материалыг бүрдүүлэхэд санхүүгийн дэмжлэг авах

4.13 Нийслэл хотыг хөгжүүлэх аливаа төсөл хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх зорилгоор хүрээлэнгийн дэргэд өөрсдийн санаачлагаар хөрөнгийн ханг байгуулж ажиллах

4.14 Улс, орон нутгийн төсөвт татвар, хураамж төлсний дараа өөрийн мэдэлд үлдэх хөрөнгийг хөдөлмөрийн хөлс, нийгмийн болон үйлдвэрлэлийг хөгжүүлэх болон бусад арга хэмжээнд зарцуулах

4.15 Ажилчдын хөдөлмөрийн хөлсийг тэдний ажлын эцсийн үр дүнд уялдуулан нэмэгдүүлэх ба бууруулан олгох журмыг хамтын гэрээнд тусгасны үндсэн дээр тогтоох

4.16 Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэх

Тав. Бусад байгууллагатай харилцах

5.1 Хүрээлэн нь Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хот байгуулалт, стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Нийслэлийн газрын алба болон бусад байгууллагатай ажлын харилцан уялдаатай ажиллана.

5.2 Хүрээлэн нь Нийслэлийн газрын албатай тусгайлан зохицуулсан журмын дагуу хамтран ажиллана.

5.3 Энэхүү дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох ба өөрчлөлт нь дүрмийн салшгүй хэсэг болно.

-----oOo-----



Нийслэлийн Засаг даргын 2004 оны
372 дугаар захирамжийн 3 дүгээр
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөрөнгө оруулалтын газар нь /цаашид газар гэнэ/ улс, хотын төсөв, орон сууц, замын сан, гадаадын зээл тусламж, бусад төрлийн эх үүсвэрийн хөрөнгө оруулалт бүхий Нийслэл улсын захиалгатай орон сууц, инженерийн байгууламж, зам, замын байгууламж, далан суваг, гэрэлтүүлэг, соёл боловсрол, эрүүл мэнд, ахуйн болон нийтийн үйлчилгээний зориулалттай барилга, объектыг шинээр барих, шинэчлэн өргөтгөх, засварлах ажилд батлагдсан хөрөнгийг зориулалтынх нь дагуу зарцуулах, түүний үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг барилга захиалагчийн үүрэг бүхий мэргэжлийн байгууллага мөн.

1.2. Газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журам, тогтоомж, барилгын норм, норматив, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шийдвэрүүд болон энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Газар нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар аж ахуйн тооцооны үндсэн дээр улсын үйлдвэрийн газрын эрхтэйгээр бие даан үйл ажиллагаа явуулж, иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээд мөн.

1.4. Газар нь тэмдэг, тушаал, албан бичгийн хэвлэмэл хуудас болон банкны харилцах данстай байна.

1.5. Газрын дарга нь улсын болон хотын төсвийн батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах бөгөөд батлагдсан орон тоо, бүтэц зохион байгуулалтыг үндэслэн ажиллагсдыг томилох, чөлөөлөх асуудлыг тушаалаар шийдвэрлэнэ. Ажлын шаардлагад зохицуулан тодорхой хугацаагаар гэрээгээр мэргэжлийн хүн авч ажиллуулж болно.

1.6. Улс, хотын хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламж, зам, замын байгууламжийн зураг төсөв боловсруулахад Дэд бүтций яам, Авто замын газрын баталсан зураг төсөв боловсруулах, батлах, зөвшөөрөлцөх зааврыг мөрдлөгө болгоно.

1.7. Газар нь архив болон замын мэдээллийн нэгдсэн сантай байна.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Газар нь нийслэлийн Засаг даргын удирдлагын дор жил, улирлын төлөвлөгөөтэй ажиллаж, улирал бүр Засаг даргын Тамгын газарт ажлаа тайлагнах бөгөөд газрын даргыг Нийслэлийн Засаг даргын захирамжаар томилж, чөлөөлнө. Газар нь захиргаа аж ахуй, хөрөнгө оруулалт, зам замын байгууламжийн хэлтэс /замын лабораторийн хамт/-тэйгээр ажиллана.

2.2. Газрын дарга нь нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр орлогч даргыг томилж, чөлөөлнө. Мөн Ерөнхий инженер, хэлтсийн дарга нартай байна.

2.3. Газрын дарга нь байгууллагын хөдөлмөрийн Дотоод журмыг баталж, цалингийн хэмжээг тогтоож мөрдүүлэх бөгөөд ажилтнуудыг томилж, чөлөөлнө.

2.4. Газрын зорилт, чиг үүрэгтэй холбогдсон асуудлыг хэлэлцэх, зөвшилцөх үүрэг бүхий захиргааны зөвлөл ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг байгууллагын Дотоод журмаар зохицуулна.

2.5. Газрын даргын эрх, үүрэг, хариуцлага, цалин хөлс, урамшуулал болон бусад харилцааг гэрээгээр зохицуулах бөгөөд энэхүү гэрээг нийслэлийн Өмчийн харилцааны газар, үйл ажиллагааны чиглэлээр Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулан ажиллана.

2.6. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг холбогдох хуулинд заасан хугацаанд хөнгөн шуурхай барагдуулах, өргөдөл гомдлын барагдуулалтыг тухай бүр тайлагнаж байна.

Гурав. Газрын гүйцэтгэх үүрэг

3.1. Газар нь Монгол улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх.

3.2. Холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, тухайн оны нийслэлийн нийгэм, эдийн засгийн зорилт, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр үнэн бодитой гаргах.

3.3. Зам, барилга, хөрөнгө оруулалтын норм, норматив, дүрэм, журам, заавар бусад хууль эрхийн актыг мөрдөх хэрэгжүүлэх.

3.4. Улс, хот, гадаадын зээл тусламжаар баригдах, засварлах бүх инженерийн шугам сүлжээ, гэрэлтүүлэг, барилгын ажилд захиалагчийн хяналт тавих.

3.5. Нийслэлийн иргэн аюулгүй орчинд амьдрах шаардлагыг харгалзан нийслэл Улаанбаатар хотод баригдаж буй өмчийн бүх төрлийн орон сууц, олон нийтийн үйлчилгээний барилгад техник хяналт тавина.

3.6. Улаанбаатар хотын авто зам, замын байгууламжийн барилга, засвар арчлалт, хамгаалалтад хяналт тавих, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа хийх зам, замын байгууламжийн төлөвлөгөөтэй холбоотой ажлыг нэгтгэн зохион байгуулах.

3.7. Нийслэлийн захиалгаар шинээр барих, их засвар хийх, бүх барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ зам, замын байгууламж, далан суваг, гэрэлтүүлэг, замын хөдөлгөөн зохицуулах, тэмдэг тэмдэглэгээ, гэрлэн дохионы ажилд шаардагдах хөрөнгийн хэмжээг тооцон жил, хэтийн төлөвлөгөөнд тусгуулах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих.

3.8. Монгол улсын Засгийн газар, хотын шугамаар гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй аливаа төслийн Монголын талын хариуцах ажлыг хэрэгжүүлэх ажлыг гардан зохион байгуулах.

3.9. Улаанбаатар хотын замын авто сүлжээг хөгжүүлэх, бодлого боловсруулахад саналаа өгөх, авто зам, замын байгууламжийг өргөтгөн шинэчлэх, засварлах, арчлан хамгаалах ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх, зарцуулалт, гүйцэтгэлд нь хяналт тавих.

3.10. Нийслэлийн захиалгаар шинээр барих, өргөтгөх, засварлах, зам, замын байгууламж, барилга, инженерийн байгууламжийг зургийн даалгаврын дагуу зураг төслийг захиалан хийлгэх.

3.11. Нийслэлийн нутаг дэвсгэрт баригдах барилга байгууламж, тэдгээрийн засвар болон автозам, замын байгууламжийн барилга угсралт, засвар арчлалт, хайгуул зураг төслийн ажил эрхлэх, батлагдсан зураг төсвийг үндэслэн зураг, төсөв, зохиогчтой гэрээ байгуулах, дүгнэх, улсын экспертиз хийлгэх ажлыг зохион байгуулах.

3.12. Хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх угсралт, их засвар, өргөтгөл шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах уралдаан зарлан шалгаруулах ажлыг зохион байгуулах, шалгарсан байгууллагатай гэрээ байгуулах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, санхүүжүүлэх мөн хотын захиалгатай ажлыг гүйцэтгэх найдвартай гүйцэтгэгч байгууллагуудыг ажлын шаардлагаар сонгон шууд захиалга өгч байх.

3.13. Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль, уг хуулийг далгалдан гарсан заавар, журмын дагуу зохион байгуулж, шалгарсан байгууллагатай гэрээ байгуулан, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж санхүүжүүлэх.

3.14. Хөрөнгө оруулалтын санхүүжилтын мэдээг сар бүр гаргаж холбогдох газар, хэлтэст өгч байх.

3.15. Хотын барилга, инженерийн шугам сүлжээ, зам, замын байгууламж, тэдгээрийн материаллаг баазыг бэхжүүлэхэд дотоодын хөрөнгө болон гадаадын зээл, хандивлагч байгууллагуудын тусламжтайгаар хэрэгжүүлэх төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулан холбогдох байгууллагад оруулах, төслийг хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, төслийг захиалж хэрэгжүүлэхэд оролцох.

3.16. Нийслэлийн замын сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг үндэслэн автозам, замын байгууламжийг барьж байгуулах, тооцоо судалгаа, техник эдийн засгийн үндэслэл, хайгуулын ажлыг зураг төслийн төлөвлөгөөнд тусгуулан, урьдчилан боловсруулж байх.

3.17. Хотын ерөнхий төлөвлөгөө, авто замын сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг үндэслэн тухайн нутаг дэвсгэр, хорооллын замыг төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлэх, замыг гэрээгээр арчлан хамгаалах ажлыг зохион байгуулах.

3.18. Тухайн жилийн замын сангийн хөрөнгийн хуваарилалтын талаар санал боловсруулж, холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр Засаг даргад өргөн барих, шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах.

3.19. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор хотын доторх замын хөдөлгөөний чиглэл тогтоох, замын аюулгүйн зурвас гарц гаргах, замын үзэгдэх орчинг хангах, шинээр авто замын орц гарц, зогсоолын талбай хийх, замын гэрлэн дохио, тэмдэг, тэмдэглэгээ хийх, мэргэжлийн байгууллагын зүгээс санал өгөх, боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах.

3.20. Нийслэлийн нутаг дэвсгэр дээрх авто зам, замын байгууламжид жил бүр тогтоосон журам, технологийн зааврын дагуу үзлэг явуулж, засвар арчлалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх.

3.21. Нийслэлийн замын санг бүрдүүлэх, хөрөнгийн эх үүсвэр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, тооцоо судалгаа хийж холбогдох газруудад танилцуулан шийдвэрлүүлэх.

3.22. Барилга угсралт, их засварын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу хийлгэж, ил, далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг гаргуулан барилга угсралтын ажлын материалыг улсын архивт, их засварын ажлын материалыг байгууллагын архивт хүлээлгэж өгөх.

3.23. Газар нь орлогоороо, зарлагаа нөхөж ажиллах бөгөөд хөрөнгө, санхүүгийн чадавхиа нэмэгдүүлэх, бизнесийн төлөвлөгөө гарган аж ахуйн тооцоон дээр ажиллан, захиалагчаар ажиллаж буй авто зам, барилга угсралт, их засварын ажлын техник хяналтын зардлаас үйл ажиллагааныхаа зардлыг нөхөх зарчмаар ажиллах.

3.24. Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, хууль зүйн хэлтэст ирүүлж хянуулах.

3.25. Газрын хэмжээнд сахилга дэг журам, ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, тэдний ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллах.

3.26. Хөрөнгө оруулалтыг дэмжих, боловсон хүчнийг сургаж мэргэшүүлэх зэрэг асуудлаар бусад орны туршлагыг судлах, хамтран ажиллах гадаад харилцааны чиг бодлогыг тогтоож, хэрэгжүүлэх.

3.27. Ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх.

3.28. Авто зам, замын байгууламжийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын талаар Замын цагдаа бусад байгууллага, албан тушаалтан, иргэдтэй хамтран ажиллана. Хууль тогтоомж зөрчсөн этгээдийг хуулийн дагуу арга хэмжээ авах, эрх бүхий байгууллагад мэдэгдэх.

Дөрөв. Газрын эрх.

4.1. Барилга байгууламж, их засварын ажлыг гүйцэтгэх технологийн дараалал, батлагдсан зураг төслийг зөрчиж чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд тухайн ажлыг буруутай этгээдийн зардлаар дахин хийлгэж улсыг хохиролгүй болгох.

4.2. Хэрэв буруутай этгээд гаргасан зөрчил дутагдлаа арилгаагүй тохиолдолд тухайн байгууллагын барилга угсралт, их засварын ажлыг уг зөрчлийг арилгатай зогсоох.

4.3. Барилга угсралт, их засварын ажлын төсөвт нөхөн сэргээх ажлын зардлыг тусгуулж, түүний үндсэн дээр урьдын байдалд нь оруулах.

4.4. Гүйцэтгэгч байгууллага тухайн санхүүжилтийг зориулалтын бус зүйлд зарцуулснаас гарсан хохирлыг арилгуулахын тулд банк, санхүү, хуулийн байгууллагаар хянуулж шалгуулах.

4.5. Барилга угсралт, их засварын ажил, авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын ажлыг батлагдсан зургийн дагуу, техникийн хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага, зураг төслийн авторын оролцоотойгоор явуулж, зөрчил, доголдлыг арилгуулах, шаардлагатай тохиолдолд зохих хууль дүрмийн дагуу хариуцагаа хүлээлгэх, ажлыг зогсоох, холбогдох байгууллагын хүмүүст асуудлыг тавьж шийдвэрлүүлэх.

4.6. Стандартын шаардлага хангаагүй, чанарын баталгаагүй материал ашиглахыг хатуу хориглож, шаардлагатай бол эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргуулах.

4.7. Барилга угсралт, их засварын ажил дууссаны дараа барилга ашиглалтад оруулах комисст хүлээлгэн өгч, комиссоос тогтоосон гүйцэтгэгч байгууллагаас хариуцах чанарын баталгаат хугацааг мөрдүүлэх.

4.8. Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийг холбогдох хууль тогтоомж, барилгын ажлын норм, норматив, үнэлгээний дагуу хянаж, гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэсэн ажилд тохирсон санхүүжилтын эрх нээх, санхүүжилт хийх, дутуу гүйцэтгэсэн ажлаас санхүүжилтийг хасах.

4.9. Барилга угсралт, их засварын ажлын норм, норматив, үнэлгээ, зураг төсөлд оруулах санал боловсруулж Дэд бүтцийн яам болон бусад байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

4.10. Хотын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн хотын доторх авто замын зэрэглэлийн дагуу замын сүлжээний хяналт тавих зурвас буюу замын улаан шугамыг нарийвчлан баримталж, энэ дагуу барилгажилтад хяналт тавин зөрчлийг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэх.

4.11. Замын сангийн, төвлөрсөн болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр нийслэлд зам, замын байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт хийх болон түүний засвар, арчлалт, хамгаалалтын ажлыг захиалан хийлгэх.

4.12. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх бүх төрлийн инженерийн шугам сүлжээний барилгын ажил гүйцэтгэх үед хотын зам, талбайг эвдэж устгасны нөхөн төлбөр, нөхөн сэргээх ажлын зардлыг тухайн ажлын төсөвт тусгуулж хотын замын санд төвлөрүүлэн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх.

4.13. Байгалийн гамшиг, гэнэтийн аюул, бэрхшээлээс шалтгаалан барилга, авто зам, замын байгууламжид эвдрэл саатал гарч түргэн засварлах шаардлага гарсан үед нийслэлийн аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс тээвэр холбооны хэрэгсэл, эд хөрөнгө, барилгын материалыг нөхөн олговортойгоор гаргуулах болон барилга, авто зам, замын байгууламжийг хэвийн байдалд оруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

4.14. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэхийн зэрэгцээ нийслэлийн төр захиргааны байгууллагуудтай үйл ажиллагааныхаа чиглэлүүдээр хамтран ажиллах.

Тав. Хариуцлага

5.1. Газрын ажилтнууд нь байгууллагын дүрэм, хөдөлмөрийн Дотоод журамд заасан үүргийг биелүүлж, байгууллагын ашиг сонирхлын төлөө шударгаар ажиллана.

Зургаа. Бусад

6.1. Энэхүү дүрмэнд нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

-----oO-----



19
Нийслэлийн Засаг даргын 2004 оны
378 дугаар захирамжийн... дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯА НИЙТИЙН ТЭЭВЭР ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн харьяа Нийтийн тээвэр зохицуулалтын газар /цаашид "газар" гэнэ / нь нийслэлийн тээврийг хөгжүүлэх талаар Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, чиглэлд тусгагдсан бодлого, удирдамжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар, Хотын захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд ажиллах Улсын Үйлдвэрийн Газар мөн.

1.2. Газрын үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нөхөрлөл, компаний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, мөрийн хөтөлбөр, энэхүү дүрмийг удирдлага болно.

1.3. Нийтийн тээвэр зохицуулалтын газрын зорилго нь Улаанбаатар хотын оршин суугчдын нийтийн тээврийн үйлчилгээний эрэлт, хэрэгцээг хангаж, хэрэглэгчдийнхээ эрх ашгийг дээдэлсэн нийтийн тээврийн тогтвортой системийг бий болгох, салбарын хүрээнд төр, нийслэлийн засаг захиргааны байгууллагын тавьсан чиг бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, нийтийн тээврийн үйлчилгээг зохицуулан зохион байгуулж, хянаж шалгах, нийтийн тээвэр эрхлэгч өмчийн олон хэвшлийн аж ахуйн нэгжүүд зохих шаардлагыг хангаж, чөлөөтэй өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх, тэднийг мэргэжлийн өндөр чадвартай, хүлээсэн үүргээ соёлч, шуурхай, чанартай биелүүлдэг болгон хөгжүүлэх явдал юм.

1.4. Газрын орлого нь нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй байгуулсан ажил үйлчилгээний гэрээний үндсэн дээр тээврийн үйлчилгээний бүртгэл, зохицуулалт, мэдээлэл, хяналт хийсний хөрс болон бусад ажил үйлчилгээний орлогоос бүрдэнэ.

1.5. Газар нь банкны байгууллагад харилцах данстай, гадаад дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй гэрээ хэлцэл байгуулан ажиллах хуулийн этгээд бөгөөд орлогоороо зардлаа нөхөх зарчмаар ажиллана.

1.6. Газар нь тогтоогдсон журмын дагуу хийгдсэн тэмдэг, бэлэгдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1.Газрын даргыг Ерөнхий менежерийн саналыг харгалзан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилж, чөлөөлнө.

2.2.Газрын орлогч даргыг Улаанбаатар хотын ерөнхий менежертэй зөвшилцсөний үндсэн дээр Газрын дарга томилж, чөлөөлнө.

2.3.Газар нь үйл ажиллагаагаа Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, түүний Ажлын албаны удирдлага дор явуулж тайлагнана.

2.4. Төрийн өмчит автобус, троллейбусны үйлчилгээний компаний захирлыг ажилд томилох, чөлөөлөх, цалин хөлсийг тогтоох асуудлыг төлөвлөж Ерөнхий менежерээр батлуулах ба компаний захиралд шагнал урамшуулал олгох, орлогч болон ерөнхий инженерийг ажилд томилох, чөлөөлөх асуудлыг Газрын дарга шийдвэрлэнэ.

2.5.Газрын дүрмийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч батлах бөгөөд, бүтэц орон тооны хязгаарыг Ерөнхий менежер тогтоон хяналт тавина.

2.6.Газрын дарга нь өөрийн дүрэмд тодорхойлогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн нэг жилд байх нийт ажлын байр, орон тоо, цалингийн сан, урамшууллын журмыг тогтоон мөрдүүлж, эрх хэмжээнийхээ хүрээнд иргэнийг ажилд авч, ажилтнуудыг томилж, чөлөөлнө.

2.7.Газрын дарга нь хууль тогтоомжинд нийцүүлэн байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам", албан тушаалын ажлын байрны тодорхойлолтуудыг батлан мөрдүүлж, нийт ажилтнуудтайгаа "Хөдөлмөрийн гэрээ" байгуулан ажиллана.

2.8.Газрын дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулалт, захирамжлалын баримт бичиг гаргаж, байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод ашиглаж, эзэмшинэ.

2.9.Газрын даргын дэргэд газрын зорилт, чиг үүрэгтэй холбогдсон асуудлыг хэлэлцэх, зөвлөх үүрэг бүхий зөвлөлийг ажиллуулах ба зөвлөлийн гишүүд гагцхүү зөвлөх эрхтэй байна.

2.10.Газрын дарга нь үйл ажиллагааны чиглэлээр Төсвийн ерөнхийлөн захирагчтай, байгууллагын биет болон мөнгөн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалт зэрэг өмчлөлийн асуудлаар нийслэлийн Өмчийн газартай гэрээ байгуулан ажиллана.

Гурав. Газрын үүрэг

3.1. Улаанбаатар хотын оршин суугчид, хэрэглэгчдийн эрх ашгийг дээдэлсэн нийтийн тээврийн тогтвортой системийг бий болгох зорилгоор нийслэл

хотын нийтийн тээврийн бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж, чанарыг дээшлүүлэх, нийтийн тээврийн үйлчилгээний талаар мөрдөгдөж буй эрх зүйн актуудыг боловсронгуй болгох талаар санал, төсөл боловсруулж шийдвэрлүүлж, түүний хэрэгжилтийг зохион байгуулна.

3.2. Хотын дотор, хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээнд аж ахуйн нэгж, байгууллагууд чөлөөтэй өрсөлдөх орчин бүрдүүлэх, тэдгээрийг тээвэрлэлтийн ажил үйлчилгээний чанар, мэрэгжлийн ур чадвар, боловсон хүчний чадавхи зэрэг үзүүлэлтийн дагуу сонгон шалгаруулж нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, аттестатчилж байх ажлыг нийслэлийн Засаг даргын эрх олгосны дагуу гүйцэтгэнэ.

3.3. Улаанбаатар хотын зорчигч тээврийн сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулах, нийтийн тээврийн үйлчилгээний салбарын материаллаг баазыг бэхжүүлэхэд дотоодын хөрөнгө оруулагчид болон олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт хамруулах талаар үндэслэн судалгаа хийж, төслийг хэрэгжүүлнэ.

3.4. Улаанбаатар хотын оршин суугчдын өсөн нэмэгдэж байгаа эрэлт, хэрэгцээ шаардлагыг хангасан нийтийн тээврийн автобус, троллейбус, таксийн тээврийн үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэхээр чиглэл, маршрут шинээр нээх, өөрчлөх, график цагийн хуваарийг тогтоох, шинэчлэн мөрдүүлэх ажлыг зохион байгуулна.

3.5. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэдтэй ажил үйлчилгээний гэрээ байгуулсны үндсэн дээр тэдгээрийн үйлчилгээний чанар, цагийн хуваарь, графикийн биелэлтэнд хяналт тавьж, өдөр тутмын шуурхай зохицуулалтаар хангана.

3.6. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын шугамын үйлчилгээнд ажилласан тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнд диспетчерийн болон Удирдлагын автомат системийн бүртгэлээр хяналт тавьж, ажлын гүйцэтгэлээр ажил үйлчилгээний гэрээ дүгнэж, хариуцлага тооцдог системийг боловсронгуй болгож ажиллана.

3.7. Нийслэл хотын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэл, маршрутын төлөвлөлттэй уялдуулан Удирдлагын автомат системийн их чадлын болон бүртгэлийн станцуудыг суурилуулан ажиллуулж, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын тээврийн хэрэгслийг хөдөлгөөнт дамжуулах станцаар тоноглох, нэвтрүүлэгч, хүлээн авагч, дамжуулагч, станцуудыг суурилуулах, засварлах ажлуудыг хийж, системийн хэвийн ажиллагааг хангаж ажиллана.

3.8. Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн санхүү эдийн засаг, үйл ажиллагааны мэдээ тайланг нэгтгэн, судалгаа дүгнэлт гаргаж, хэрэглэгчдийн болон тээвэр эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалж, нийтийн тээврийн үйлчилгээг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, удирдах дээд шатны байгууллагуудад зохих журмын дагуу тавьж шийдвэрлүүлнэ.

3.9. Тээврийн үйлчилгээнд дангаар ноёрхох явдлыг хязгаарлаж, өрсөлдөөн өрнүүлэх замаар хотын нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тарифыг уян хатан байлгах зах зээлийн зарчим, төрийн бодлогыг хэрэгжүүлж ажиллана.

3.10. Нийтийн тээврийн хэрэгслээр хөнгөлөлттэй болон үнэ төлбөргүй зорчих эрх бүхий оюутан, албан үүргээ гүйцэтгэж яваа цагдаагийн байгууллагын ажилтан, ахмад настан тахир дутуу иргэдийн унааны зардлын нөхөн олговрыг тус газрын ерөнхий менежерийн Төсвийн ерөнхийлэн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээнд заасан хугацаанд нийслэлийн төсвөөс авч, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад ажлын гүйцэтгэлийг үндэслэн хуваарилан олгоно.

3.11. Нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт тавих, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор хотын доторх замын хөдөлгөөний чиглэл тогтоох, замын гэрэл дохио, тэмдэг, тэмдэглэгээ байгуулахад мэргэжлийн байгууллагын зүгээс санал өгөх, автобусны буудал зогсоол, тээврийн хэрэгсэлд байрлуулах чиглэл, маршрутын зураглал, хаяг, дугаар зэрэг үйлчилгээний мэдээллийг боловсронгуй болгох, автобус, таксийн тээврийн автовокзал, буудал зогсоол байгуулах санал, асуудал боловсруулж шийдвэрлүүлнэ.

3.12. Нийслэлийн нийтийн тээврийн хөдлөх бүрэлдэхүүний паркийн зохистой бүтцийг бүрдүүлэх зорилгоор хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, техник ашиглалтын шаардлагад илүү нийцтэй, эдийн засгийн хэмнэлттэй тээврийн хэрэгслээр нөхөн хангалт хийх, стандартын шаардлага хангасан их багтаамжийн автобусыг импортоор оруулж ирэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг дэмжиж ажиллана.

3.13. Улаанбаатар хотын хэмжээнд автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоог жилийн турш явуулах, Техникийн хяналтын төвүүдийг байнгын ажлаар хангах ажлыг зохион байгуулна.

3.14. Хэрэглэгчдийн болон авто тээвэр эрхлэгчдийн нийтлэг эрх, ашгийг хамгаалсан төрийн бус байгууллагатай авто тээврийг хөгжүүлэх, , зохих түвшинд хүрсэн мэргэжлийн авто аж ахуйн нэгжийг бэхжүүлэх, тогтвортой хөгжлийг хангаж, үйлчилгээний соёл, чанарыг дээшлүүлэх, хөндлөнгийн болон өөрийн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, харилцан туслалцаа үзүүлнэ.

3.15. Нийслэл хотод ачаа, ахуйн тээврийн үйлчилгээ эрхэлдэг тээврийн хэрэгсэл бүхий аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, үйл ажиллагааг дэмжин, мэргэжлийн удирдлагаар хангах, нэгдсэн зохион байгуулалтанд оруулж, хяналт тавина.

3.16. Авто тээврийн талаар мөрдөж байгаа хууль тогтоомж, түүнд нийцүүлэн төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас гаргасан стандарт, дүрэм журам, авто тээврийн хэрэгслийн техникийн хяналт, нийтийн тээврийн тусгай зөвшөөрөлд заасан үүргийн биелэлт, нийтийн тээврийн чиглэл, цагийн хуваарь, үйлчилгээний журмын мөрдөлт, тээвэрлэгч, зорчигчийн үүргийн биелэлт, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж байгаа эсэхэд захиргааны хяналтыг хэрэгжүүлж, тэдгээрийг боловсронгуй болгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.17. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах бодлого баримталж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсны үндсэн дээр инженер техникийн ажилтан, жолооч, кондукторуудыг мэргэшүүлэн сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулна.

3.18. Нийтийн тээврийн үйлчилгээний талаархи иргэдийн санаа бодлыг судалж, иргэд зорчигчдын хүсэлт гомдлыг хүлээн авч, шуурхай барагдуулан, тэдэнд дэмжлэг үзүүлж ажиллана.

3.19. Нийслэлийн хэмжээнд тээврийн ажил үйлчилгээ эрхлэгчид болон тээврээр үйлчлүүлэгч нарт хэрэглэгдэх тусгай зөвшөөрөл, үйлчилгээний хуудас, замын хуудас, гэрчилгээ, нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчих эрхийн үнэмлэх зэрэг бичиг баримт болон зорчигчийн тасалбар, оюутны хөнгөлөлтийн марк зэрэг үнэт цаасыг батлагдсан загварын дагуу нэгдсэн журмаар хэвлүүлж хангах, тэдгээрийн ашиглалт, зарцуулалтанд хяналт тавина.

3.20. Нийтийн тээврийн үйлчилгээний төрийн өмчит компаниудын дүрэм, бүтэц зохион байгуулалт, ажиллах цагийн хуваарь, тухайн сард гүйцэтгэх цаг рейсийн төлөвлөгөөг баталж мөрдүүлэх ба санхүүгийн тайланг улирал тутам авч, судалгаа дүгнэлт гарган, удирдамж чиглэл өгч ажиллана.

3.21. Нийтийн тээврийн үйлчилгээний компаниудын материаллаг баазыг бэхжүүлэх, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, хөдлөх бүрэлдэхүүний паркийн шинэчлэлт, нөхөн хангалт хийх асуудлыг гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, төрийн өмчийн компаниудыг хувьчлах асуудлыг шийдвэрлүүлэх ба гадаад оронд туршлага судлах, суралцах ажлыг нэгтгэн зохион байгуулна.

3.22. Ажилтнуудын нийгмийн асуудлыг хэтийн болон жил бүрийн бизнес төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, байгууллагын хэтийн зорилтонд тулгуурлан хүний нөөцийг төлөвлөх, сургаж дадлагажуулах, боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх, ажилтнуудын ажиллах идэвхи санаачлага, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ажлын байрны нөхцлийг сайжруулах арга хэмжээг төлөвлөн зохион байгуулна.

Дөрөв. Газрын эрх

4.1. "Монгол улсын төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль", бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу газрын өмч хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах, захиран зарцуулах.

4.2. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд тусгай зөвшөөрөл олгох, ажил үйлчилгээний гэрээ, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг зөрчсөн тохиолдолд түүнийг хүчингүй болгох.

4.3. Нийтийн тээврийн ажил үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад бүртгэл, зохицуулалт, мэдээлэл, хяналт шалгалтын ажил үйлчилгээ үзүүлсэн ажил үйлчилгээний хөлсийг гэрээний үндсэн дээр төвлөрүүлэн авах.

4.4. Газрын хариуцах асуудлаар гадаад орны болон өөрийн улсын холбогдох байгууллагатай бие даан харилцах, Нийслэлийн Засаг даргын болон холбогдох эрх бүхий байгууллагын эрх олгосны дагуу гэрээ хэлцэл хийж, хамтран ажиллах.

4.5. Хотын дотор авто тээврийг хөгжүүлэх, үйлчилгээний бүртгэл, хяналт зохицуулалтанд шинэ техник технологи нэвтрүүлэх, чиглэл, төсөл, техник эдийн засгийн үндэслэлд экспертиз хийж, санал дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх.

4.6. Улаанбаатар хотын хэмжээнд тээврийн сүлжээг шинэчлэн өөрчлөх, хотын тээврийн үйлчилгээг хүн амд ойртуулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор үйлчилгээний чиглэлийг шинээр нээх, өөрчлөх, хаах талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх.

4.7. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагуудын эрх баригчдад өмчийг хүлээлгэн өгч эзэмшүүлэх, тэднийг ажилд томилох, чөлөөлөх болон иргэний гэрээнд тусгах эрх, үүрэг хариуцлага зэрэг асуудлаар төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэгч холбогдох байгууллагад санал өгөх.

□ 4.8. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай зөвшилцсөний үндсэн дээр газар нь өөрийн салбар нэгжийг байгуулан ажиллуулах

4.9. Нийслэлийн нутаг дэвсгэрт авто тээврийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, төрийн захиргааны төв байгууллага, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн биелэлтийг хангуулж, авто тээврийн улсын хяналтыг хэрэгжүүлэх.

Тав. Эд хөрөнгө, санхүүгийн бүртгэл, хяналт

5.1. Газар нь Монгол улсын хууль, тогтоомжийн дагуу татвар төлнө.

5.2. Газар нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар гаргаж, Татварын алба, Санхүүгийн байгууллагад тушаана.

□ 5.3. Санхүүгийн тайлан нь Нягтлан бодох үртгэлийн олон улсын стандартад нийцсэн, харилцагч, хэрэглэгчдийн нийтлэг эрх ашгаас урган гарсан, тэдэнд үнэн зөв мэдээллэл авах шаардлага хангасан байна.

5.4. Газар нь үндсэн хөрөнгө, үнэт цаас, мөнгөн хөрөнгийн дотоодын болон улсын тооллогыг хуулинд заасан хугацаа, журмыг үндэслэн явуулна.

5.5. Газар нь өмч хөрөнгөө эзэмших, ашиглах, түрээслүүлэх, шилжүүлэх, худалдах, устгах, хувьчлах, үнэлэх асуудлыг "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-нд заасан журам, эрх хэмжээнд хэрэгжүүлнэ.

5.6. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө Газрын дарга, бүртгэлээр тавих хяналт шалгалтыг Ерөнхий нягтлан бодогч хариуцна.

5.7. Эд хөрөнгийг бүртгэн авч хадгалах, нэр төрөл, чанар, бүрдлийн хувьд бүрэн бүтэн байлгах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тавьж олгох эд хариуцагчийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу сонгон авч, "эд хөрөнгийн хариуцлагын гэрээ" байгуулан ажиллана.

Зургаа. Хариуцлага

6.1. Газрын ажилтнууд нь байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам", "Хөдөлмөрийн гэрээ"-нд заасан үүргийг биелүүлж, байгууллагын ашиг сонирхлын төлөө шударгаар ажиллана.

6.2. "Хөдөлмөрийн тухай хууль" тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээхээргүй бол газрын эрх бүхий албан тушаалтан, байгууллага нь уг хуулийн 141 дүгээр зүйлийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.3. Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтан сахилгын, захиргааны , эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээнэ.

6.4. Газрын дарга нь эрх мэдлээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж байгууллагадаа хохирол учруулсан бол уг хохирлыг өөрийн хувийн өмчийн эд өрөнгөөр бүрэн хариуцна.

6.5. Газрын дарга нь Монгол улсын хууль тогтоомж, НИТХ-ын болон Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж , бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол холбогдох хуулийн дагуу шүүхийн өмнө хариуцлага хүлээнэ.

Долоо. Бусад

7.1. Энэхүү дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох ба өөрчлөлт нь дүрмийн салшгүй хэсэг болно.

-----oO-----

НИЙСЛЭЛИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ШТАБЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Гамшгаас хамгаалах штабын зорилго нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, Нийслэлийн хэмжээнд гамшгаас хамгаалах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд оршино.

1.2 Гамшгаас хамгаалах штаб нь нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг бөгөөд үйл ажиллагааныхаа үр дүнгээр Нийслэлийн Засаг даргад үйлчилгээ, дэмжлэг үзүүлж үйл ажиллагаандаа Монгол улсын хууль, тогтоомж Гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын даргын тушаал, Нийслэлийн Засаг даргын захирамж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3 Гамшгаас хамгаалах штаб нь дүүргийн Гамшгаас хамгаалах штаб, Гал унтраах анги, аврах отрядын үйл ажиллагааг мэргэжил, арга зүй, хяналт, зохион байгуулалтын удирдлагаар хангаж ажиллана.

1.4 Гамшгаас хамгаалах штабын орон тоог Гамшгаас Хамгаалах Ерөнхий Газрын дарга батална.

1.5 Гамшгаас хамгаалах штаб нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1 Гамшгаас хамгаалах штаб нь Мэргэжлийн удирдлагын хэлтэс, Тамгын хэлтэс, Хяналтын хэлтэс, дүүргийн Гамшгаас хамгаалах штаб, Гал унтраах анги, Аврах отрядтай байна.

2.2 Гамшгаас хамгаалах штабын дарга, хэлтсийн дарга нарыг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга томилно.

2.3 Гамшгаас хамгаалах штабын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг шийдвэрлэхэд даргад зөвлөх эрхтэй даргын зөвлөл ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг штабын даргын тушаалаар батална.

Гурав. Газрын үүрэг

3.1 Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих

- 3.2 Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор дайчилгаа зохион байгуулах
- 3.3 Гамшгийн цагийн байдалтай холбогдсон хойшлуулшгүй асуудлаар санал боловсруулан Гамшгаас хамгаалах ерөнхий газрын удирдлага, Нийслэлийн Засаг даргад уламжлах:
- 3.4 Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд нийтээр дагаж мөрдөх заавар, журам, норм, нормативийн хэрэгжилтийг хангахад хяналт тавих.
- 3.5 Нийслэлийн Засаг даргыг гамшгаас хамгаалах талаархи мэдээллээр хангах.
- 3.6 Алба хаагчдын ажлын байрны нөхцөл, хөдөлмөр хамгаалал, аюулгүйн техникийн ажиллагаанд судалгаа хийж түүнийг сайжруулах арга хэмжээ авах.
- 3.7 Алба хаагчдыг сургалтанд хамруулан мэргэшүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх

Дөрөв. Газрын эрх

- 4.1 Штабын нэрийн өмнөөс бусад байгууллагатай харилцах, төлөөлөх.
- 4.2 Гамшгаас хамгаалах ажлыг гүйцэтгэхэд шаардагдах хүн хүч, техник, материал, багаж хэрэгслийг Нийслэлийн засаг даргын шийдвэрийн дагуу дайчлах.
- 4.3 Гамшгаас хамгаалах талаар тооцоо, судалгаа, мэдээ материалыг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргуулан авах.
- 4.4 Батлагдсан төсөв болон хандив, тусламжийн хөрөнгийг зохих журмын дагуу захиран зарцуулах.
- 4.5 Ашиглалтын хугацаа дууссан болон бусад шалтгаанаар цаашид ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг данснаас хасах, худалдах асуудлыг шийдвэрлэх.
- 4.6 Гадаад орон, олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн дагуу олгосон эрхийн хүрээнд гэрээ, хэлэлцээр байгуулах, хамтран ажиллах.
- 4.7 Байгууллагын үйл ажиллагаа, ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах.
- 4.8 Төрийн тусгай алба хаагчийг томилуулахаар Гамшгаас хамгаалах ерөнхий газарт санал оруулах, төрийн үйлчилгээний алба хаагчийг томилох.
- 4.9 Гал унтраах , Аврах отрядыг байгуулах, орон тоо, нормативийг өөрчлөх, татан буулгах болон бусад шаардлагатай асуудлаар Гамшгаас хамгаалах ерөнхий газар, Нийслэлийн засаг Засаг даргад санал боловсруулан оруулж шийдвэрлүүлэх.

Тав. Бусад

- 5.1 Энэхүү дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба өөрчлөлт нь дүрмийн салшгүй хэсэг болно.

-----oOo-----